

4/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 13




Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 4 дүгээр сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд + 29.6 °C-д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 4 дүгээр сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +29.6°C, үнэмлэхүй бага температур Хөвсгөл аймгийн Хатгал суманд -21.6°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖТАЙ¹ ХАРЬЦУУЛСНААР, станцын байршлаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 4 дүгээр сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Баянхонгор аймгийн Баянбулаг суманд 27.0 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Дундговь аймгийн Мандалговь сумын нутгаар түр зуур 34 м/с-д хүрсэн байна.


Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 2021 оны 4 дүгээр сард бүх станцуудад 0.014 мг/м³–0.075 мг/м³-д хүрсэн бөгөөд 1-р хороолол, Хайлааст, Зурагт орчимд 0.061 мг/м³–0.075 мг/м³-д агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.011 мг/м³–0.025 мг/м³-ээр давсан байна.


Харин азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2021 оны 4 дүгээр сард бүх станцуудад 0.017 мг/м³–0.041 мг/м³-д хүрсэн бөгөөд агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна.

PM 10 тоосонцрын сарын дундаж агууламж 2021 оны 4 дүгээр сард бүх станцуудад 0.026 мг/м³ – 0.137 мг/м³-д хүрсэн бөгөөд Баянхошуу орчимд 0.137 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.037 мг/м³ –ээр давсан бол Хархорин зах орчимд 0.100 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжийн түвшинд байжээ.


ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мг/м³



ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 2.5 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³




ЗУРАГ 4. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 10 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³



Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисуудын дундаж агууламжийг авч үзвэл, 2021 оны 4 дүгээр сард азотын давхар исэл өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м³ (27.0%)-ээр, өмнөх сараас 0.010 мг/м³ (27.9%)-ээр, PM 2.5 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.013 мг/м³ (44.6%)-ээр, өмнөх сараас 0.018 мг/м³ (52.0%)-ээр, PM 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.036 мг/м³ (63.4%)-ээр, өмнөх сараас 0.165 мг/м³ (38.1%)-ээр тус тус бага байсан бол хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.014 мг/м³ (62.0%)-ээр их, өмнөх сараас 0.035 мг/м³ (49.4%)-ээр бага байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мг/м³



ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станцаар, 2021 оны 4 дүгээр сард

| Станцын байршил | Хүхэрлэг хий (SO ₂) | Азотын давхар исэл (NO ₂) | Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO) | Тоос (PM ₁₀) | Тоос (PM _{2.5}) | Озон (O ₃) |
|------------------------|---------------------------------|---------------------------------------|---------------------------------|--------------------------|---------------------------|------------------------|
| Мишээл экспо | 1 | - | - | 5 | - | - |
| Баруун 4 зам | 8 | 7 | - | 1 | - | - |
| 1-р хороолол | 15 | - | - | 4 | - | - |
| 13-р хороолол | - | 1 | - | 3 | - | - |
| 32-ын тойрог | 12 | 3 | - | 4 | - | - |
| Хархорин | 1 | - | - | 11 | - | - |
| Ургах наран хороолол | - | - | - | 2 | - | - |
| Хайлааст | 19 | - | - | - | - | - |
| 248-р цэцэрлэг | 10 | - | - | - | - | - |
| Богд хааны ордон музей | - | - | - | - | - | - |
| Нисэх | 1 | - | - | 5 | - | 5 |
| Толгойт | - | - | - | - | - | - |
| Зурагт | 19 | - | - | - | - | 5 |
| Амгалан | - | - | - | 2 | - | - |
| Баянхошуу | - | - | - | 14 | - | - |

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 4 сард 1485 болж, өмнөх оны мөн үеэс 277 (15.7%)-гоор буурсан байна. Объектын түймэр 987 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 394 (28.5%)-өөр буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 4 сард сард боом өвчний 1, мал, амьтны халдварт галзуу өвчний 10, шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 23189 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 I – IV | 2019 I – IV | 2020 I – IV | 2021 I – IV | <u>2021 I – IV</u> 2020 I – IV |
|----------------------------------|---------------|-------------|-------------|-------------|-------------|-----------------------------------|
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдол | тоо | 1 709 | 2 074 | 1 762 | 1 485 | 84.3 |
| Амь насаа алдсан хүн | тоо | 45 | 49 | 59 | 205 | 3.5 ¹ |
| Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн | тоо | 29 | 24 | 66 | 23 232 | 352.0 ¹ |
| Шатсан гэр, орон сууц | тоо | 607 | 721 | 662 | 309 | 46.7 |
| Объектын түймэр | тоо | 1 346 | 1 817 | 1 381 | 987 | 71.5 |
| Учирсан хохирол | тэрбум төгрөг | 13.4 | 4.2 | 91.3 | 7.9 | 8.7 |
| Зарцуулсан зардал | сая төгрөг | 9 918.8 | 540.1 | 105.1 | 517.7 | 4.9 ¹ |

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 4 сард нийт 205 хүн амь насаа алдаж, 23232 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон байна.

Амь насаа алдсан шалтгааныг нь авч үзэхэд бичил уурхай, нурангийн улмаас 3 хүн, усны ослоор 8 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн, объектын түймрийн улмаас 28 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 127 хүн, бусад золгүй явдлын улмаас 28 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 4 сард 309 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 353 (53.3%)-аар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 4 сард 7.9 тэрбум төгрөгийн хохирол учирч, 517.7 сая төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний 4 сард 1230 хүнийг аварч, 32.2 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 6 дугаар сарын 15



Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Д.Баасан
Утас : (976-51)-261502